



Арвайн хүрээний “Тарган бандида” ламтан Цэвэлванчигдоржийн зохиосон малын өвчнийг анагаах арга, заслын судруудыг судалсан дүн

Я.Ганзаяа^{1*}, Х.Сүглэгмаа²

¹ Ганданпунцоглин хийд, Өвөрхангай аймаг

² Төрийн өмчит Улаанбаатар их сургууль

*Холбоо барих хаяг: gnzy_ya@yahoo.com

ХУРААНГУЙ

Арвайн хүрээний “Тарган бандида” хэмээн алдаршсан Цэвэлванчигдорж мал эмчилгээний төвд үсгийн “Ka”-аас “Ca” хүртэл тэмдэглэсэн таван хэсгээс бүрдсэн нэг боть зохиол бичжээ. “Ka” хонины эмчилгээний сударт 60 гаруй өвчин, 130 орчим эмчилгээ, дом заслууд, “Kha” адууны эмчилгээний сударт 70 гаруй зүйлийн өвчнийг анагаах 100 гаруй төрлийн эмчилгээний арга засал, “Ga” буюу үхрийн эмчилгээний сударт 17 өвчин, 50 орчим төрлийн эмчилгээний арга засал, “Nga” тэмээний эмчилгээний сударт 40 гаруй өвчин, 80 гаруй төрлийн эмчилгээний арга, “Ca” ямааны эмчилгээний сударт 5 өвчин, 9 төрлийн эмчилгээ, мөн аж амьдралын талаархи 6 төрлийн аргууд зэрэг нийт 192 төрлийн өвчин, түүнийг анагаахад ашиглагддаг 369 эмчилгээний арга заслыг түүвэрлэн бичсэн байна.

Түлхүүр үг: өвчнийг анагаах судар, өвчин, домнох, ханах, аж амьдралын ухаан

ОРШИЛ

Зохиогч Ч.Цэвэлванчигдорж нь тухайн малчин ардуудын хэрэглэж байсан мал эмчилгээний арга, дом засал, аж амьдралын ухаануудыг төрөл бүрийн мэргэжлийн хүмүүсийн яриа, зөвлөмжөөс тэмдэглэн бичсэн байна. Тус зохиолыг төвд хэлээр бичсэн боловч зарим өвчнүүдийн нэршил, эмчлэх ургамал, дом засалд хэрэглэх эд зүйлс, газар нутгуудын монгол нэрийг төвд үсгээр үгчлэн бичсэн байдгаараа төвд хэлт зохиолуудаас онцлогтой юм. Уг эмчилгээний судар нь эхэндээ “Багш дор мөргөмү” хэмээх мөргөлийн хэсэг ба

мал сүргийн өвчин, чоно нохойны хорлол, газрын эзний хорлол, малын гарлага тэргүүтэнд номын рашаанаар угаал үйлдэх, ариулгын арцыг адислах, ариулах ёсон, мал тус тусын өр төлөөсийг хариулах, мал сүргийг тэжээгч өвс, усыг адислах ёс зэрэг зан үйлүүд, тэдгээрийн бодлуудыг бичжээ. Мөн мал хариулагч малчдад хамаг амьтныг хайрлах, туслах санааг төрүүлэх тухай, хүн малд хорлогч амьтдын муу санаа үйлдлийг амирлуулах тухай, чонын хорлолыг амирлуулах тухай тайлбаруудыг бичсэн байна.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэхүү судалгааг явуулахдаа нийтэд өргөн хэрэглэгддэг анализ, синтез, индукци, дедукци,

түүвэрлэх болон орчуулгын аргуудыг хэрэглэсэн болно.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Монголын номын мэргэдийн нэг, XIX зууны дунд үеийн эрдэмт лам нарын нэрт төлөөлөгч Арвайн хүрээний “Тарган бандида” хэмээн алдаршсан Ч.Цэвэлванчигдорж нь мал эмчилгээний 5 төрөл судрыг эмхэтгэн бичжээ. Эдгээр судрууд төвд үсгийн “Ka”-аас “Ca” хүртэл тэмдэглэсэн таван хэсгээс бүрдсэн нэг боть зохиол болжээ. Үүнд: “Ka” буюу хонины эмчилгээний судар нь “Малчин тэргүүтэнд тус хүргэх, мал сүргийг тэтгэх

аргын дарааллаас нийт хийгээд ялангуяа хонины өвчнийг анагаахын аймаг оршвой” (rdzi bo sogs la phan ‘dogs par bya rgyu phyugs skyong thabs kyi rim pa rnam las spyi dang bye brag lug nad bcos pa’i bskor lags) хэмээх нэртэй. Хонины эмчилгээний сударт 60 гаруй өвчин, 130 орчим эмчилгээ, дом заслуудыг багтаажээ [1]. “Kha” буюу адууны эмчилгээний судар нь “Малчин тэргүүтэнд туслах морийг тэтгэх

аргын дараалал, морины өвчнийг анагаахын аймаг оривой” (rdzi bo sogs la phan ‘dogs par bya rgyu rta skyong thabs kyi rim pa rta nad bcos pa’i bskor lags) хэмээх нэртэй. Адууны эмчилгээний сударт 70 гаруй зүйлийн өвчнийг анагаах 100 гаруй төрлийн эмчилгээний арга заслыг бичжээ [2, 6].

“Ga” буюу үхрийн эмчилгээний судар нь “Малчин тэргүүтэнд тус хүргэх, мал сүргийг тэтгэх аргын дараалал, үхэр хийгээд сарлагийн өвчнийг анагаахын аймаг оривой” (rdzi bo sogs la phan ‘dogs par bya rgyu phyugs skyong thabs kyi rim pa las glang dang gyag nad bcos pa’i bskor lags) хэмээх нэртэй. Үхрийн эмчилгээний судар нь эхэндээ Лхамноржма бурханд даатгасан хэсэг ба “үхэр, сарлаг, хайнаг, үнээ тэргүүтний эмгэг өвчин, халдварт хижиг өвчинд тус хүргэх анагаахын аргад өвчний ялгал нь үхрийн гэдэсний хатгалгаа, архаг хатгалгааны зүйл...” хэмээн нийт 17 өвчин, 50 орчим төрлийн эмчилгээний арга заслыг бичжээ [3, 7].

“Nga” буюу тэмээний эмчилгээний судар нь “Малчин тэргүүтэнд туслах тэмээг тэтгэх аргын дараалал, тэмээний өвчнийг анагаахын аймаг оривой” (rdzi bo sogs la phan ‘dogs par bya

rgyu rnga mong skyong thabs kyi rim pa rnga mong gi nad bcos pa’i bskor lags) хэмээх нэртэй. Тэмээний эмчилгээний судар нь малын тэнгэр “Нирбу”-д даатгасан залбирал ба “тэмээний эмгэг өвчин, уналга, ачлагаас үүдсэн бэртлийн өвчний зүйл, хорт өвчин, хорт ногоо идсэний гэм, нойтон хүйтнээс болсон шээс хаагдахын шалтгаан, гэдэс дүүрэх, хөөх ба хөл унжих, доголох тэргүүтэнд туслах анагаахын арга нь...” хэмээн эхлээд нийт 40 гаруй өвчин, 80 гаруй төрлийн эмчилгээний арга заслыг бичжээ [4,8].

“Ca” буюу ямааны эмчилгээний судар нь “Малчин тэргүүтэнд туслах ямааг тэтгэх аргын дараалал, ямааны өвчнийг анагаахын аймаг оривой” (rdzi bo sogs la phan ‘dogs par bya rgyu ra skyong thabs kyi rim pa ra nad bcos pa’i bskor lags) хэмээх нэртэй. Ямааны эмчилгээний судар эхэндээ ямааны тэнгэр “Цэрма”-д даатгасан залбирал ба “га хэмээх монгол хэлэнд ямаа гэх тэр, ямааны эмгэг өвчинд туслах, анагаахын арга нь ямааны өвчин “годрон” хэмээх төвд хэлээр “rto nad” гэх түүнд усанд зэсийг буцалгаад бал зэвтэй усыг өгнө...” хэмээн эхлээд нийт 5 өвчин, 9 төрлийн эмчилгээ, 6 төрлийн аж амьдралын аргуудыг бичжээ [5].

Table 1

Some diseases of livestock and methods of treatment		
Малын төрөл	Өвчний төрөл,	Эмчилгээ, дом
	тоо	засал
Хонь	60	130
Адуу	70	100
Үхэр	17	50
Тэмээ	40	80
Ямаа	5	9
Нийт	192	369

Бид судалгааны үр дүнд нийтдээ 192 өвчин, эдгээр өвчин эмгэгийг эмчлэх, засах 396 арга байгааг илрүүлэн, тэдгээрийн дотроос олонтоо тохиолддог өвчнүүд болон илүүтэй хэрэглэдэг аргуудыг онцлон авч үзэв.

Адууны судрын эмчилгээний хэсэг эхлэхдээ “Морины эмгэг өвчин ба уналгаас болж цус хямрах, өвс уснаас болж шээс алдах, хордох зэрэгт туслах анагаахын арга, мөн морины бүлдэгт үр гаргасны гэмээр rta red хэмээхийг монгол хэлэнд “соёнготох”, lto spos-д ‘gre ldog хэмээхийг “хөрвөөх”, уралдах хийгээд давхих хүч олсон боловч уналгаас болсон өвчнийг “дэлсэх, түгших” хэмээх тэдгээрт нэрмэл архи тустай”. “Морь мал гэнэт муужран унаваас монгол хэлээр “дайрлага” гэх ба хэлний үзүүрээс гурван хуруу авах ба хэлний судсыг ханаж цус гаргаваас сайн” хэмээн эмгэг өвчнүүдийн шалтгаан, шинжүүдийг тайлбарласан байна. Энд нэгэн зүйлийг дурьдахад

монгол нэршлийг нь бичсэн байх ба тухайн өвчний төвд нэршлийг бичээд ард нь монгол нэршлийг төвд үсгээр үгчлэн зааж, харин төвд нэршилгүй язгуурын монгол нэршлийг төвд үсгээр үгчлэн бичсэн хоёр хэлбэртэй бичжээ. “Морины даарь яр ба чоно нохой зуусан шарх”-нд худгийн хүйтэн усыг чадах хирээр цацваас сайн. “Чоно хялгана” хэмээх говь газар ургадаг зарааны үс адил ургамлын шатаасан үнс нь малын яр шарх бүхэнд сайн”, “Морины жилбэн”-д хонь буюу зээрний “зулч”-ийг нойтон, хуурай алиныг ч эрхий хурууны үеийн хэмжээтэй бага зэргээр өгвөөс сайн гэдэг. Бас “морины жилбэн”-д чонын цөсийг хэлээр нь долоолговоос сайн. Туулайн арьсыг морины нурууны “дайр яр”-ны идээ бээрийг нь арилгаад нааваас сайн...” хэмээн эмчилгээнд байгалийн ус ургамал, амьтны гаралтай зүйлсийг хэрэглэхийг заасан ба ургамлын ургах газар, гаднах хэлбэр, хэрэглэх

хэмжээг танилцуулсан байна. “Илжгэн чих” хэмээх чавганы доторх ясыг гаргаж морины “сахуу” өвчинд өгөх хэрэгтэй. Бас түүний дээр хятадууд иддэг “*byi mkhal*” буюу “хулганы бөөр” хэмээхийг усанд буцалгаж хөргөөд өгнө. Үүний ард “Хүний өвчинд эмчилгээ мухардаж бусад юугаар ч үл туслах хавдар өвчинд дээд тустай” гэсэн тайлбар зүүсэн байна. Олон хятад хүмүүс сайшаасан хэмээн үр дүнг нь үзсэн маарамба Дэлэг хэлэв.” хэмээн малын өвчнөөс гадна хүний өвчинд тустай болохыг амьдрал дээр хэрэглэсэн эмчийн хэлснээс эшлэн тэмдэглэжээ [2,6]. “Морийг унаж ирээд салхи цохиулж нуруу нь хавдваас хацрын судсыг ханаснаар тустай. Гүрээний судасны үндэс хацрын судасны доод захад ханана. Ер нь морины өвчинд цээжний судасны цусыг ханаваас тустай”. “Мориор явах үед урд хөл бүдэрч доголвоос туурайн өмнө харалдаа дээд захын “нүд” хэмээх түүнийг ханаваас сайн. Морины хөл тулж явж чадахгүй доголвоос аль тулсан хөлнөөс чөдөр буюу сур аргамжаар уяж урагш татаж дээш гурвантаа цовхруулваас сайн” хэмээн морь малын өвчин эмгэгт уламжлалт ханах аргыг хэрэглэж, ханах судсуудын нэр, ханах цэг, гэмтэл бэртлийг засах аргуудыг заасан хэсгүүд олон байна. “Бусдаас авсан морь өөрийн нутаг руу буцаж гүйвээс “цагаан гүгэл”-ээр утна. Уралдах морины хурд хүчинд тустай”. “Морь, ялангуяа замд хол унах морийг усны захад олмыг бүү чийгтүүл. Хүч тамир барахын гэмтэй. “Цагаалж” хэмээх өвс маш хэрэгтэй, “ширх” хэмээх ногоо, өтөг бууц газар ургасан ногоо үл зохино” хэмээн морь мал эдэлж арчлах тухай бичжээ. “Жилбэн” хэмээх өвчин уналгаас болох ба нойтон чийг, хүйтэн ус зэргээр хөлс гарсан даруйд дааруулсан зэргээс болсон”¹, “Хорхой” өвчинд бие сулраад, хүч доордоод, өвс үл иднэ”. “Гэтү” хэмээх нь морины далны дээр ба биеийн цээж овойж хавдах” гэх зэргээр өвчнүүдийн шинж шалтгаануудыг нарийн тоочсон байдаг. Шившиж тарнидах арга заслуудыг өвчинд хэрэглэсэн нь “Морь ба илжиг тэргүүтний шагай булрах болвоос *ум до на до на, ди жү ди жү, чүла, ди* хэмээх тарнийг найман настай нялхсын шээсэнд шившиж өгвөөс эдгэх болно”, “морь малын хоолойд ус алдваас *ум жити жинан түм түм нан* хэмээх тарнийг архи буюу усанд тарнидаад өгвөөс тустай”, морь мал хор идвээс *ум мари хам суха* тарнийг усанд олонтаа тарнидаад адууны хамрын нүхэнд цутгаваас эдгэх болно” хэмээсэн хэсгүүд байдаг. Зохиолын төгсгөлийн хэсэгт “*Охин тэнгэрийн сонгины угаалга*” хэмээх судрыг хавсаргажээ.

Хонины өвчнийг анагаах сударт “Хонины гэдэс нь хөөж түргэн зуурт үхэхийг монгол хэлэнд “түргэн” буюу “*татвалзуур*” гэх бөгөөд уг өвчинд хиргэсүүрийн чулуунаас нэгийг авчраад хонь хэвтсэн газарт булаад дараа нь чулууг андууралгүйгээр урьдын байсан газар нь аваачиж тавина. *Хиргэсүүр* гэдэг нь үхэгсдийн шарилыг булсан газарт чулуу овоолсон байгааг хэлэх ба тэр газрын *савдаг, шивдаг бирдэд* махны үнэрээр хиншүүт өглөг өгөх нь тустай”. “*Хөшөө*” хэмээх нь тэмдэг тавьсан өндөр чулуу мэтийг хэлнэ. *Ертөнцийн тэнгэрийг* тахирын тулд босгосон, түүний дэргэд болон ойр орчмоос аргал мод овоолж гал түлж хиншүү хярвас гаргаж өглөг өг...” хэмээн хонины өвчинд хиргэсүүрийн чулуугаар домнох буюу хиргэсүүр булш, хөшөө чулууны газрын эзэн савдгийг тахиж өглөг өгөх нь тустай болохыг дурджээ.

“Хонины *татвалзуур* өвчинд өвчнөөр үхсэн хонины гүзээг үлээгээд бууны суманд “*ямараза*” тэргүүтэн хагуу тарнийг тарнидаад гүзээг буудваас хонины өвчин амирлана. Аль ч малыг өвчнөөр үхэхэд тэр мэт үйлдэх хэрэгтэй” хэмээн малын өвчинд гүзээг нь үлээж буугаар буудах аргыг хар домын судраас бичсэн байна.

Үхрийн өвчнийг анагаах сударт “*Цагаан өвгөн* хэмээх өвчин нь гэдсэнд бууваас цусаар уруугаа суулгаж үхнэ. Өөрөө үхсэн малын цусыг өгвөөс “*Лхантав*”-ын нууц эм мэт болно. Тэр нь халдварт өвчин мөн тул алинаас хэрхэн халдварлах гэвэл *арьс, мах, цус, яс, сэвс* тэргүүтний үнэр үнэртэх ба өвчтэй үхрийн ам хамрын шүлс гоожиж савирсан өвс, уснаас эрүүл үхэр идэж уух, цас мөсийг долоох, өвчтэй эрүүл хоёрыг нэг газарт нийлүүлэн хариулах, хамт хэвтэх тэргүүтнээр халдварлана” хэмээн малын халдварлах замыг анхааруулжээ. “Өвлийн цагт үхрийн “*мэлэн* өвчний үед үхрийг даруулахгүй байх нь хэрэгтэй тул эсгийгээр бүрхэх, өвөлжөө бууц, хот хороондоо тохируул. Анхны гурваас дөрөв хоногт нь хүйтэн усыг бүү өг. Сүүлд нь өвс идээд “*хэвлэг авах*” хэмээн бага зэрэг идэх үед нь буцалсан усыг бүлээн болгоод сар мичидийн гэрлийг тусгаж өчүүхэн багаар өлсгөсөн байдлаар өгнө” хэмээн үхрийн өвчинд бүлээн усыг хэрэглэхдээ сар, одны гэрлийг тусгаж өгөх тухай байна. “Өвлийн хүйтэнд хөл нь хөлдөөд “*эмгээлз*” хэмээх хөлний үзүүр унах гэм байна. *Бойтог* хэмээхийг олж цуглуулваас хүйтнээс аврагдана. Их хүрээний худалдааны газар сүүлний үзүүр нь хөлдсөн мэт гурав, дөрвөн хуруу орчим хатаж хорчийсон байгааг гараар барьж, тэмтэрч үзээд урьд өвдсөн эсэхийг танин

мэд” хэмээн өвлийн их хүйтэнд малын хөлд бойтог өмсүүлэх тухай болон зах, худалдааны газар зарагдаж байгаа үхрийг урьд өмнө нь өвдсөн эсэхийг шинжиж сэрэмжлэх аргыг бичжээ. “Хумча” буюу “хунчир” хэмээх өвсийг усанд буцалгаад хөргөж дахин дахин өгвөөс их сэрүүн чанартай тул үхрийн халуун өвчинд дээд тустай. Зун цагт сүүг гашилгахгүйн тулд хунчирыг сүүн дотор хийвээс гашилж амт чанар нь муудахаас сэргийлнэ” хэмээн сүү цагаан идээг гашилгахгүй, муутгахгүй байх аргыг давхар дурджээ.

Тэмээний өвчнийг анагаах сударт: “Тэмээний хорхой” өвчин гэдэг нь үс хялгас мэт байдалтай өт хорхой өдөр нь гэдсэн дотор, үдэш хийгээд үүрийн харанхуй цагт хоолой багалзуурт ирдэг. Тэр үед нь төмөр дөрөөг аманд нь хийж ангайлгаад гараа угааж, хумсаа авч Даш хадгаар гараа ороож, хүүхэн хэлний цаад талд багалзуур дотроос гараа шанага байдлаар өтийг малтаж авна. Түүнийг авахдаа гараараа хэлийг нь дарж алгуур өтөнд мэдрэгдэхгүй авна” хэмээн тэмээний хорхойг гараар түүж авах аргачлалыг бичсэн энэхүү хэсэгт монгол мал эмчилгээний сонин содон аргууд олон байна.

“Тэмээнд өлзийтэй газар нь алин мөн хэмээхэд Шаралдай хайрхан хэмээх уул өлзийтэй. Тэр уулыг хошууч Бэйсийн хошууны ранжамба Дагва хэмээх эм эмчилгээний охин тэнгэрийг бүтээж равнайж оршоосон. Үржил тэмээчин Цагаан заан хэмээх Зүүн аймгийн нэгэн хүн түүнээс Хайрханы тухай асуухад хайрханы ойр зүг буюу өндөр газраас тахиж хэрэгтэй. Энэ хайрхан нь буур шавах байдалтай. Баруун хойд зүгээс харагдах газрын шинж юм. Урд зүгт нь Эрдэнэ хэмээх булаг, тэр нь өөрөө гарсан гэдэг. Цагаан

ШҮҮН ХЭЛЭЛЦЭХҮЙ

Ч.Цэвэлванчигдоржийн малын эмчилгээний судраас морь, үхэр, тэмээний эмчилгээ заслын судрыг 1927 онд Судар бичгийн хүрээлэнгийн гишүүн н.Гэлэгжамц дооромбо орчуулсан нь эдүгээ Монгол улсын үндэсний номын сангийн гар бичмэл, монгол судлалын сан хөмрөгт 12282/97 кодтойгоор хадгалагдаж байна. Тус орчуулгын адууны судрын ард н.Гэлэгжамц дооромбо өөрийн орчуулсан тухайгаа бичсэн нь “Үүнийг Монгол Ард Улсын 17-р он, ХҮГ жарны тэргүүн улаагчин туулай жилийн хаврын тэргүүн сарын 10-ны өдөр Судар бичгийн хүрээлэнгийн гишүүн н.Гэлэгжамц төвдөөс монгол хэлээр орчуулсан болно” гэжээ. [6].

Харин бидний энэ удаагийн судалгаанд адуу, үхэр, тэмээ, хонь, ямаа гээд 5 хошуу малын өвчин, эдгээрийг засах аргууд өргөн хүрээтэй

заан хэмээх тэрээр Шаралдай хайрханыг аль харсан зүгээсээ тахиж тайснаар тэмээн сүрэг нь арвижсан. Харин тэр хайрханд хүн хөдөөлүүлвээс нас богиносно. Ахар нэртэй уул нь нэрийнхээ үүднээс өлзий бус, дайсан газрын дунд ирнэ гэдэг. Түүнийг засахдаа Урт наст таван эгч дүүс хийгээд Цагаан замбалын дүр хөргийг бүтээж чандмань эрдэнийг тэр хоёрын дунд байрлуулваас болно, ажиглах хэрэгтэй” хэмээн тэмээнд өлзийтэй газар нутгийг зааж, газрын сайн шинжийг дэлгэрүүлж тахиж баяагах, муу шинжийг засаж залруулах аргыг бичсэн байна.

Ямааны өвчнийг анагаах сударт: “Зарим хүмүүсийн удам дамжсан аюулт өвчнийг засахын арга нь хүн өвчнөөр үхэх болоод амьсгал тасрах үед нь харааж зүхэж, үүдний босгоо ойл сүхээр цавчиж тасална. Мөн амьсгал тасрахын сүүлийн нэг амьсгалыг саван дотор оруулж аваад амыг нь сайтар таглаж, босгоны доор булваас өвчнийг дийлнэ” хэмээн үе удам дамжсан аюулт өвчний удамшлыг таслах арга домьг дурджээ. “Хуцны толгойг өндөр газар уулын оройд бүү тавь. Нам доор хот хороо, бууцныхаа малын хаашаан дотор тавибаас хонин сүрэг арвидна. Үхсэн нохойгоо хонхор нам дор газар тавибаас нохой тогтохгүй дахин дахин үхэх гэмтэй. Мөн эзнийх нь цог хийморь доройтож хийморьгүй болох тул хонхор доор газар бүү тавь. Давааны орой, өндөр газар тавибаас өлзийтэй” хэмээн малчин хүний аж амьдралын ухааныг дурджээ. “Хүчтэй хуй салхи ирэх зүгт гэрийн ойрхон хажууд өндөр мод хатгаснаар салхины хүч тэр модоор хуваагдаж хүч нь сулрах тул гэр хөдлөхгүй тустай” хэмээн монголчуудын амьдралын ухаан, арга домьг бичжээ.

хамрагдсан ба 5 хошуу малд тохиолдох өвчин, тэдгээрийн эмчлэх аргын талаархи бидний орчуулгын бүтээлтэй адил төстэй эрдэм шинжилгээний ажил хараахан гараагүй байна. Энэхүү сударт дурдагдсан малын өвчин, эмгэгүүдийн нутгийн (уламжлалт) нэрийг орчин үеийн мал эмнэлгийн шинжлэх ухааны батлагдсан нозологийн нэршилтэй дүйцүүлэх, ижилсүүлэх, жиших, эсвэл зэрэгцүүлэн хэрэглэх судалгааны ажил огт хийгдээгүй байгаа нь харагдаж байна.

Мөн өвчин, эмгэгийн шинж тэмдгийг одоо үеийн мэдээлэлтэй харьцуулан үзэж, Европын мал эмнэлгийн эмнэл зүй, эмгэг жамаар тайлбарлах, түүнчлэн эсвэл хэрэглээнээс хасах, эсвэл хүлээн зөвшөөрөх онолын болон хавсарга судалгаа,

туршилтын салбарыг хөгжүүлэхийг зөвлөж байна.

Ардын уламжлалт мал эмнэлэгт хэрэглэж ирсэн ургамал, амьтан, эрдсийн гаралтай эмийн түүхий эдүүдийг сударт заасан аргын дагуу малын төрлөөр, өвчний заалтаар эмийн тодорхой хэлбэрт оруулан эм зүйн үүднээс судлах нь шинэ шинэ эмийн түүхий эдийг илрүүлэх нэг гол сэдэв гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ

1. XIX зууны номын мэргэд ихэнхдээ буддын гүн ухааны чиглэлээр зохиол бүтээлээ туурвисан байдаг бол бандида ламтан Ч.Цэвэлванчигдорж нь буддын гүн ухааныг ард олны аж амьдралын арга ухаан, дом засал, тэр дундаа малын өвчний эмчилгээ, засалтай холбож зохиол бүтээлээ туурвисан байна.
2. Таван хошуу малын 192 төрлийн өвчин, түүнийг анагаахад ашиглагддаг 369 төрлийн эмчилгээний дом заслыг Ч.Цэвэлванчигдорж

Цаашид ардын мал эмчилгээний арга, заслын гүнзгийрүүлсэн судалгааг дэлхий дахинаа шинээр үүсч хөгжиж байгаа *Ethno veterinary medicine*-тай уялдуулан хөгжүүлж, 19 дүгээр зууны ардын мал эмчилгээ, заслын нэрт төлөөлөгч “Цэвэлванчигдорж судлал”-ыг хөгжүүлэх нь шинжлэх ухааны нэг чухал хандлага болох юм.

- өөрийн бүтээлдээ оруулан бичсэнээс гадна Арвайн хошуутай холбоотой газар усны нэр, домог, түүхэн үйл явдлын баримтуудыг багтаасан байна.
3. Тус зохиолд малын өвчин, засал эмчилгээ, эд хэрэгслийн нэршлийн төвд үгийг монгол орчуулгаар нь төвд үсгээр үгчлэн бичсэн нь уншигч, судлаач нарт төвд үгийн уламжлалт орчуулгыг мэдүүлэх хэл шинжлэлийн чухал хэрэглэгдэхүүн болжээ.

АШИГЛАСАН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

- [1] Ч.Цэвэлванчигдорж, “rdzi bo sogs la phan ‘dogs par bya rgyu phyugs skyong thabs kyi rim pa rnam las spyi dang bye brag lug nad bcos pa’i bskor lags” (Малчин тэргүүтэнд тус хүргэх, мал сүргийг тэтгэх аргын дарааллаас нийт хийгээд ялангуяа хонины өвчнийг анагаахын аймаг оршвой).
- [2] Ч.Цэвэлванчигдорж, “rdzi bo sogs la phan ‘dogs par bya rgyu rta skyong thabs kyi rim pa rta nad bcos pa’i bskor lags” (Малчин тэргүүтэнд туслах морийг тэтгэх аргын дараалал, морины өвчнийг анагаахын аймаг оршвой).
- [3] Ч.Цэвэлванчигдорж, “rdzi bo sogs la phan ‘dogs par bya rgyu phyugs skyong thabs kyi rim pa las glang dang gyag nad bcos pa’i bskor lags” (Малчин тэргүүтэнд тус хүргэх, мал сүргийг тэтгэх аргын дараалал үхэр хийгээд сарлагийн өвчнийг анагаахын аймаг оршвой).
- [4] Ч.Цэвэлванчигдорж, “rdzi bo sogs la phan ‘dogs par bya rgyu rnga mong skyong thabs kyi rim pa rnga mong gi nad bcos pa’i bskor lags” (Малчин тэргүүтэнд туслах тэмээг тэтгэх аргын дараалал, тэмээний өвчнийг анагаахын аймаг оршвой).
- [5] Ч.Цэвэлванчигдорж, “rdzi bo sogs la phan ‘dogs par bya rgyu ra skyong thabs kyi rim pa ra nad bcos pa’i bskor lags” (Малчин тэргүүтэнд туслах ямааг тэтгэх аргын дараалал, ямааны өвчнийг анагаахын аймаг оршвой).
- [6] Адгуулагч тэргүүтэнд тус хүргэх, морийг тэтгэх аргын зэрэг морины өвчин анагаахын “жой” оршвой. aduyuluyci teriguten-dü tusa kürgökü morin-u tedgekü [=tedgükü] arу-a-yin jerge morin-ü ebedcin anayaqu-yin joi [=bcos] orusiba.
- [7] Адгуулагчин тэргүүтнээ тус хүргэх, малыг тэтгэхийн аргын зэргээс үхэр хийгээд сарлагийн өвчнийг анагаахын үеэс болой. aduyuluycin [=aduyuluycin] teriguten-e tusa kürgökü mal-i tedgekü-yin [=tedgükü-yin] arу-a-yin jerge-ece üker keged [=kiged] sarлуу-un ebedcin-i anayaqu-yin üyes bolai.
- [8] Адгуулагч тэргүүтэнд тус хүргэх, тэтгэхийн аргын зэрэг тэмээний өвчнийг анагаахын үеэс оршвой aduyuluyci [=aduyuluyci] teriguten-dür tusa kürgökü temegen-i tedgükü-yin jerge temegen-ü ibedce-i [=ebedchin-i] anayaqu-yin üyes orusiba.

The study of treatment methods for animal diseases completed by lamtan Tsevelvanchigdorj “Targan bandida” of Arvai khuree

Ganzaya Yagaan^{1*}, Suglegmaa Khurgaa²

¹ Gandanpuntsoglin monastery, Uvurkhangai province, Mongolia

² Ulaanbaatar state university, Ulaanbaatar, Mongolia

*Corresponding author: gnzy_ya@yahoo.com

ABSTRACT

Tsevelvanchigdorj, popularly known as the “Fat Bandida” of the Arvain khuree, wrote a five-part text at the Veterinary Center, marked with the letters “Ka” to “Ca”. More than 60 diseases, about 130 treatments and treatments in “Ka” sheep treatment scripture, more than 100 types of treatment methods to cure more than 70 diseases in “Kha” horse treatment scripture, 17 diseases and about 50 types of treatment methods in “Ga” or cattle treatment scripture. A total of 192 diseases and 369 treatments used to treat more than 40 diseases, more than 80 types of treatment in the “Nga” camel treatment scripture, 5 diseases and 9 types of treatment in the “Ca” goat treatment scripture, as well as 6 types of life methods surgery is sampled.

KEY WORDS: The scriptures for the cure of disease, sickness, affliction, satiety, the wisdom of life